

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

---

"МАНДАЛ ЭНЕРГО" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2022/09/НА-СТА-ОНА**

---

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: [dalaivandarkhan@gmail.com](mailto:dalaivandarkhan@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ...	9
3.Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	12
4. Аудитын тайлан .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Дотоод хяналт .....	14
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
4.4. Материаллаг байдал.....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
8. Аудитын илрүүлэлт.....	16
8.1 Зөвлөмж.....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18



“МАНДАЛ ЭНЕРГО” ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Д.ЦЭРЭНДАГВА ТАНАА

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/09-НА-СТА-ОНА  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мандал энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Мандал энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

СЭА-2022/09-НА-СТА-ОНА

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/			
Д/д	Үзүүлэлт	2020.01.01	2021.12.31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,617,196.83	1,708,691.65
1.1.2	Дансны авлага	49,057,522.22	71,484,678.33
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	513,778.58	315,860.04
1.1.4	Бусад авлага	9,664,669.96	9,769,469.44
1.1.6	Бараа материал	89,560,150.63	70,999,445.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	515,300.00	934,700.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>153,928,618.22</b>	<b>155,212,844.83</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,019,366,399.22	974,671,078.23
1.2.2	Биет бус хөрөнгө	60,370,727.13	59,598,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,079,737,126.35</b>	<b>1,034,269,078.23</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,233,665,744.57</b>	<b>1,189,481,923.06</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	72,386,240.00	46,253,215.01
2.1.1.3	Татварын өр	11,453,352.29	9,727,100.85
2.1.1.4	НДШ - ийн өглөг	127,233.26	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	10,357,188.38	8,785,303.57
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>94,324,013.93</b>	<b>64,765,619.43</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0	0
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>94,324,013.93</b>	<b>64,765,619.43</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	250,535,268.80	250,535,268.80
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,632,360.38	2,632,360.38
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,087,529,569.34	1,037,427,343.73
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-201,355,467.88	-165,878,669.28
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,139,341,730.64</b>	<b>1,124,716,303.63</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,233,665,744.57</b>	<b>1,189,481,923.06</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2020.01.01	2021.12.31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	816,713,424.18	992,524,064.60
2	Борлуулалтын өртөг	781,138,131.42	839,559,050.76
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	35,575,292.76	152,965,013.84
8	Бусад орлого	3,909,090.90	7,890,909.11
10	Ерөнхий ба удирдлагын зардал	106,979,157.68	115,706,517.55
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	0	3,628,930.29
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	847,130.71	
17	Бусад ашиг ( алдагдал)	0	2,101,810.00
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	-68,341,904.73	39,418,665.11
19	Орлогын татварын зардал	0	3,941,866.51
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	-68,341,904.73	35,476,798.60
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	-68,341,904.73	35,476,798.60
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	0	0
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	-68,341,904.73	35,476,798.60
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<b>250,535,268.80</b>	<b>2,632,360.38</b>	<b>1,087,529,569.34</b>	<b>(201,355,467.88)</b>	<b>1,139,341,730.64</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,087,529,569.34	(201,355,467.88)	1,139,341,730.64
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	<b>250,535,268.80</b>	<b>2,632,360.38</b>	<b>1,087,529,569.34</b>	<b>(201,355,467.88)</b>	<b>1,139,341,730.64</b>
Залруулсан үлдэгдэл				(201,355,467.88)	(201,355,467.88)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				35,476,798.60	35,476,798.60
Бусад дэлгэрэнгүй орлого			(50,102,225.61)		(50,102,225.61)
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	<b>250,535,268.80</b>	<b>2,632,360.38</b>	<b>1,037,427,343.73</b>	<b>(165,878,669.28)</b>	<b>1,124,716,303.63</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2020.01.01	2021.12.31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	857,839,185.87	1,039,133,831.65
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	855,274,023.57	1,038,782,981.65
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,923,686.00	87,372.00
	Бусад мөнгөн орлого	641,476.30	263,478.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	807,585,955.19	980,376,336.83
	Ажиллагчдад төлсөн	243,906,349.00	199,308,369.92
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,734,787.30	88,446,379.28
	Бараа материал худалдан авахад төлсөн	321,807,647.15	454,545,880.30
	Ашиглалтын зардалд төлсөн	54,982,835.00	99,233,688.56
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	55,387,523.00	34,685,974.00
	Татварын байгууллагад төлсөн	59,978,672.55	77,502,324.48
	Бусад мөнгөн зарлага	13,788,141.19	26,653,720.29
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>50,253,230.68</b>	<b>58,757,494.82</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,276,881.78	61,666,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	24,018,181.78	61,666,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	23,258,700.00	
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-47,276,881.78</b>	<b>-61,666,000.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	0
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b><u>2,976,348.90</u></b>	<b><u>-2,908,505.18</u></b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,640,847.93	4,617,196.83
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	4,617,196.83	1,708,691.65

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт	м/төг				
	а/Дулаан түгээлтийн орлого	м/төг	809,456.10	880,362.00	-70,905.90	109%
	б/Ус хангамж, ариутгах татуургын орлого	м/төг	50,183.30	57,196.40	-7,013.10	114%
	в/Мах бэлтгэх төвийн орлого		66,352.00	41,309.00	25,043.00	62%
	<b>Бусад орлого</b>	м/төг	5,000.00	21,547.60	-16,547.60	431%
2	<b>Нийт орлого</b>	м/төг	<b>930,991.40</b>	<b>1,000,415.00</b>	-69,423.60	107%
3	<b>Нийт зардал</b>	м/төг	<b>917,067.70</b>	<b>960,996.20</b>	-43,928.50	105%
	<b>Үүнээс: Удирдлагын зардал</b>	м/төг		<b>115,706.50</b>	-115,706.50	
4	Татварын өмнөх ашиг	м/төг	13,923.70	39,418.70	-25,495.00	283%
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг			0.00	
6	<b>Төсвийн төлбөр</b>	<b>м/төг</b>	<b>808.40</b>	<b>210,078.00</b>	-209,269.60	25987%
	а/Орлогын татвар	м/төг		3,941.80	-3,941.80	
	б/НӨАТ	м/төг		102,228.90	-102,228.90	
	в/НДШ	м/төг	47,971.30	84,602.20	-36,630.90	176%
	г/ХАОАТ	м/төг		18,496.70	-18,496.70	
	д/ҮХЭХАТ	м/төг	808.4	808.4	0.00	100%
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	39	38	1.00	97%
8	Нийт цалингийн сан	м/төг	313,766.80	199,308.40	114,458.40	64%
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	8045.3	5244	2,801.30	65%
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг			0.00	
11	Хөрөнгө оруулалт	м/төг	66,139.80	63,858.00	2,281.80	97%
12	Нийт авлага	м/төг		81,254.20	-81,254.20	
	Үүнээс: найдваргүй	м/төг			0.00	
13	Нийт өглөг	м/төг		64,765.60	-64,765.60	
	Богино хугацаат өглөг	м/төг		64,765.60	-64,765.60	
	Урт хугацаат өглөг	м/төг				

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь “Мандал сумын төвийн хэсгийн хэрэглэгчдийг ажиллах амьдрах тав тухтай нөхцөлөөр хангаж ажиллах” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх, түгээх,
- Мал нядалгааны цех эрхлэх,
- Цэвэр ус дамжуулан борлуулах.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 45 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,617.2	1,708.7	(2,908.5)
Авлага	59,235.9	81,254.2	22,018.3
Татвар, НДШ-ийн авлага		315.8	315.8
Бараа материал	89,560.2	70,999.4	(18,560.8)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	515.3	934.7	419.4
Үндсэн хөрөнгө	1,079,737.1	1,034,269.1	(45,468.0)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,233,665.7</b>	<b>1,189,481.9</b>	<b>(44,183.8)</b>
Өр төлбөр	94,324.0	64,765.6	(29,558.4)
Эздийн өмч	1,139,341.7	1,124,716.3	(14,625.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,233,665.7</b>	<b>1,189,481.9</b>	<b>(44,183.8)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,908.5 мянган төгрөгөөр буурсан нь 1,161,969.0 мянган төгрөгийн орлого олж, 1,234,547.6 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 81,254.2 мянган төгрөг болж 22,018.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төр, төсвийн байгууллагуудаас авах халаалт, усны авлага / *үнэ тарифын зөрүү* / 62,805.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэлд дараах авлагууд бүртгэгдсэн байна. Үүнд:

- Төр, төсвийн байгууллагуудаас авах халаалт, усны авлага 62,805.7 мянган төгрөг,
- Тохилог Хараа ОНӨААТҮГ-ын халаалтын авлага 4,004.6 мянган төгрөг, сантехникийн засвар үйлчилгээний ажлын хөлсний авлага 3,190.0 мянган төгрөг,
- Айл өрхийн халаалт, усны авлага 132.3 мянган төгрөг,

- ААН-ийн халаалт, усны авлага 5,039.0 мянган төгрөг,
- Мах бэлтгэх төвийн үйлчилгээ шинжилгээний авлага 132.5 мянган төгрөг,
- Сантехникийн засвар үйлчилгээний авлага 170.2 мянган төгрөг, СӨХ-өөс авах авлага 3,758.1 мянган төгрөг,
- Иргэн Отгонбаатараас 2,021.8 мянган төгрөг гэх мэт.

Бараа материалын дансны үлдэгдэл 70,999.4 мянган төгрөг болж 18,560.8 төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 418,638.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 437,198.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Урьдчилж гарсан зардал 934.7 мянган төгрөг болж 419.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь УБТЗ-ын ХНН-д урьдчилж төлсөн тээврийн хөлснөөс голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 159,299.5 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 123 дугаар тогтоолоор 231,450.0 мянган төгрөгийн машин механизмыг Тохилог Хараа ОНӨААТҮГ-т, 2,600.0 мянган төгрөгийн тракторыг Тарни 8-р багт тус тус шилжүүлсэн, аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 494 дүгээр тушаалын дагуу үлдэх өртөггүй 20,470.0 мянган төгрөгийн анхны үнэ бүхий хөрөнгийг 8,787.3 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 55,430.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсанаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 64,765.6 мянган төгрөг болж 29,558.4 мянган төгрөгөөр буурахад Шивээ овоо ХК-д өгөх өглөг 26,133.0 мянган төгрөгөөр, татварын өр төлбөр 1,726.3 мянган төгрөгөөр, урьдчилж орсон орлого 1,571.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 127.3 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл (165,878.7) мянган төгрөг болж, өмнөх оноос 35,476.7 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан алдагдал буурсан болон тайлант үеийн ашиг нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн дүн 1,124,716.3 мянган төгрөг болж 14,625.4 мянган төгрөгөөр буурахад 234,050.0 мянган төгрөгийн хөрөнгө данс хооронд шилжүүлсэн, тайлант оны ашиг 35,476.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

#### **3.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 615 дугаар тогтоолоор “Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 930,991.4 мянган төгрөгөөр, нийт зардлыг 917,067.4 мянган төгрөгөөр, ашгийг 13,924.0 мянган төгрөгөөр тогтоож, хөрөнгө оруулалтын 8 арга хэмжээнд 83,339.1 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,000,414.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 960,996.3 мянган төгрөгийн зардал гарган, 39,418.6 төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлжээ. Үүнд:

- Халаалтын орлого 880,362.0 мянган төгрөг,
- Усны орлого 53,513.7 мянган төгрөг,
- Үйлчилгээ шинжилгээний орлого 41,309.0 мянган төгрөг,
- Түрээсийн орлого 7,890.9 мянган төгрөг,
- Худгийн усны орлого 437.3 мянган төгрөг,
- Худгийн картын орлого 877.5 мянган төгрөг,
- Засвар үйлчилгээний орлого 2,367.8 мянган төгрөг,
- Сантехникийн засвар үйлчилгээний ажлын хөлсний орлого 13,659.7 мянган төгрөг.

Нийт орлогын гүйцэтгэл 1,000,414.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 69,423.5 төгрөг буюу 7.0 хувиар давуулан биелүүлсэн нь аж ахуйн нэгж, айл өрхийн дулаан, цэвэр усны орлого, сантехникийн засвар, үйлчилгээний орлого нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 960,996.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 43,928.6 төгрөг буюу 4.6 хувиар хэтэрсэн нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 39,418.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 25,494.6 мянган төгрөгөөр давж биелэхэд нийт орлогыг 7.0 хувиар давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн байна.

## **4. Аудитын тайлан**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Мандал Энерго” ОНӨААТҮГ -ийн /цаашид “Мандал Энерго” ОНӨААТҮГ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ, Ж.Сайнбилэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Дотоод хяналт**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **4.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 960,996.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,609.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,726.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

Харин төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэн батлаагүй байна.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 264.0 мянган төгрөгийн 1 акт, 15,957.4 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 2,140.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	264.0	1	264.0	100.0
Албан шаардлага	4	15,957.4	4	15,957.4	100.0
Зөвлөмж	3	2,140.0	3	2,140.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>18,361.4</b>	<b>8</b>	<b>18,361.4</b>	<b>100.0</b>

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 96,354.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### 8.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.Татварын өр төлбөртэй холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Тайлант оны 6,143.9 мянган төгрөгийн орлогыг НӨАТ-ын тайланд дутуу тайлагнасан нь татварын хяналт шалгалтаар акт, өр төлбөр тавигдах эрсдэлийг үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.6-д “*... тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах*”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Албан татварыг доор дурдсан журмаар ногдуулна ...8.1.1-д “*бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### 1.2. **Өгсөн зөвлөмж:**

2022 оны 1 дүгээр улиралд багтаан залруулж бүртгэх, цаашид холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллах.

## 2. Цалин хөлстэй холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт:** Нүүрс буулгасан ажлын хөлс 2,400.0 мянган төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаж, тайлагнаагүй байгаа нь НДШ-ийн акт, өр төлбөр тавигдах эрсдэлийг үүсгэж . Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.1 “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Цаашид холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллах.

## 3. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

3.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 87,810.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

3.2 **Өгсөн зөвлөмж:** Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

## 4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

4.1 **Илрүүлэлт** Шилэн дансны цахим хуудсанд 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3-дахь заалтуудыг зөрчсөн байна.

4.2 **Өгсөн зөвлөмж:** Цаашид холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>															
1	Мандал Энерго ОНӨААТҮГ	СЭА-2022/09/-НА-СТА-ОНА	Татварын тайланд орлого дутуу тайлагнасан	1	6,143.9									1	6,143.9
2	Мандал Энерго ОНӨААТҮГ	СЭА-2022/09/-НА-СТА-ОНА	Нүүрс буулгасан ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй	1	2,400.0									1	2,400.0
3	Мандал Энерго ОНӨААТҮГ	СЭА-2022/09/-НА-СТА-ОНА	Бараа материалын худалдан авалт нь цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй.	1	87,810.1									1	87,810.1
4	Мандал Энерго ОНӨААТҮГ	СЭА-2022/09/-НА-СТА-ОНА	Шилэн дансанд 6 мэдээлэл дутуу мэдээлсэн.											1	
<b>ДҮН</b>				<b>4</b>	<b>96,354.0</b>									<b>4</b>	<b>96,354.0</b>
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>															
1															
<b>ДҮН</b>															
<b>НИЙТ ДҮН</b>															